

ШИНЭ (НИЙГМИЙН, ЭКО) МУЗЕЙ СУДЛАЛЫН СУДАЛГАА

Сүндэвийн Энхнаран

Соёл, урлаг судлалын хүрээлэн, Улаанбаатар, Монгол улс
bbe3mn@gmail.com

Хураангуй: Уламжлалт музей судлалын хөгжлийн дараах үе шат нь нийгмийн хөгжлийг дэмжих, тогтвортой байдлыг хангах, хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах хэрэгцээ шаардлагаас урган хөгжиж, музейн хоёрдугаар хувьсгалыг эхлүүлсэн талаар өгүүлнэ. Мөн манай улсын музей судлалыг нийгмийн болон эко музейн онолоор шинжилж, дүгнэсэн.

Түлхүүр үг: музейн хувьсгал, музейн хувьсал, нийгмийн үүрэг, хариуцлага, эколог

NEW MUSEOLOGY STUDIES: SOCIAL MUSEOLOGY AND ECOMUSEUM

Enkhnarán Sundev

Culture and Arts Research Institute, Ulaanbaatar, Mongolia
bbe3mn@gmail.com

Abstract: This paper examines the second museum revolution which is the next stage of the development of traditional museological studies, which flourished out of the need to support social development, ensure sustainability, and protect the environment. Additionally, the museology of our country was analyzed and evaluated by falling into the theory of social and eco-museum.

Keywords: museum revolution, museum evolution, social role and responsibility, ecology

1972 онд Чилийн Сантьяго хотод музейн мэргэжилтнүүд “Сантьягогийн дугуй ширээний уулзалт”-ыг хийсэн юм. Уулзалтаар музейн утга учир, нийгмийн үүргийг эргэцүүлэн тунгаахдаа музей нь эдийн засгийн хөгжилд, тэр дундаа хүмүүс нь ядуу амьдардаг бүс нутагт ямар үүрэг гүйцэтгэх, ямар хувь нэмэр оруулах билээ. Музей, нийгмийн зорилго хоёр яаж уялдах, хот, хөдөө, алс хязгаарын ядуу иргэдийн хөгжилд хэрхэн хувь нэмрээ оруулах вэ зэрэг асуултад хариулт хайж хэлэлцсэн юм (Revista Museum, 1973, 225). Ард түмэн, иргэдэд зориулсан олон нийтийн музей хөгжүүлэх, орон нутгийн иргэдтэй хамтрах хөгжлийн хөтөлбөрийн санаа олж, музейг илүү ардчилсан алсын хараатай болгосон. Сантьягогийн дугуй ширээний уулзалтаас гарсан тунхаг бичиг музей судлалын онол, практик, бодлогод нөлөөлж,



дэлхийн даяар соёлын салбар музейнүүдээ эргэн тунгааж, нийгмийн үүрэг, хариуцлагыг өөрчилснөөр музейн дэд хувьсгалын үндэс суурь болсон байна.

1970-аад оны үеэс Францын музейнүүдэд нийгмийн үүрэг, хариуцлага хүлээлгэх хэлэлцүүлэг мэтгэлцээн хүчтэй өрнөсөн, уг үзэл санааг “*Nouvelle Muséologie*”-оор нэр томъёолсныг Францын музей судлаач Андрей Десвальеес нэвтэрхий толь (*Encyclopaedia Universalis*, 1980)-д бичиж тайлбарласан юм. Үүнээс өмнө “шинэ музей судлал” гэсэн нэр томъёо гарч байсангүй. Ингэж “Шинэ музей судлал” нь олон нийтийн хөгжлийн хөтөлбөртэй холбогдох музей судлалын онцлох нэр томъёо бүхий ойлголт болж, Испани, Португал зэрэг Европын олон оронд аажмаар түгээмэл болжээ. Шинэ музей судлалын хувьсгалаас Олон нийтийн музей судлал (*Community museology*), Нийгмийн музей судлал (*Social museology*), Нийтлэг музей судлал (*Popular museology*), Идэвхтэй музей судлал (*Active museology*), Оролцооны музей судлал (*Participative museology*), Экомузей судлал (*Ecomuseology*), Газар нутгийн музей судлал (*Territorial museology*) зэрэг онолын чиглэлүүд дэлхийн зарим улс орнуудад хүчээ аван өргөн тархаж, зарим улс оронд хязгаарлагдмал хүрээнд хөгжиж байгаа. Мөн нийгмийн музей судлал, экомузей судлал нь англи, испани зэрэг хэлээр монограф болон сурах бичгийн дорвитой судалгаатай байгаа бол бусад чиглэлүүд нь музей судлаачдын бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, лекц семинарын үзэл санаа, онолуудыг түлхүүрдэн таних, тодорхойлолт, ойлголтын түвшинд байна.

П.Дэвис “шинэ музей судлал”-ыг 1950 оны үед АНУ-д музейн боловсролын үүрэг хүлээхэд; 1980-аад оны үед Их Британид олон нийтийн музейнүүд нэмэгдэж, музей нийгмийн үүрэг хүлээхэд; өмнө өгүүлсэн “*Nouvelle Muséologie*” гэсэн нэр томъёог нэвтэрхий толь (*Encyclopaedia Universalis*, 1980)-д тайлбарласнаар музейн сурвалж, сурах бичигт дор хаяж гурван учир шалтгаан, газар нутаг, утга агуулгын улмаас нэвтэрсэн (2011, 61) гэжээ. Харин Шведийн музей судлаач Керстен Смедс (Kerstin Smed) шинэ музей судлалыг өнгөрсөн зуун жилд дор хаяж гурван удаа давлагаалж илэрсэн гэж үзэж байна. Нэгдүгээрт, 20-р зууны нэгдүгээр хагаст Францын музейнүүд олон нийтийн боловсролын үүрэг хүлээх үеэс музейн үзэл суртал, нийгмийн үүрэгтэй уялдаж илэрсэн. Өрнөдийн нийгмийн ардчилал, орчин үетэйгээ хөл нийлүүлэн музейнүүд өргөн олонд илүү нээлттэй болсон. Хоёрдугаарт, 1970 оны зүүн европ, францад музейн үүрэг, нийгмийн хариуцлагыг шүүн хэлэлцэж, мэтгэлцээний талбар болох үеэр илэрсэн. Музейд тэн хагасаас илүүтэй жин дарсан эдийн соёлын өвийн ажлаас нийгмийн шүүмжит өнгөт харилцаа руу шилжих, ингэхдээ соёлын өвд үндэслэн нийгмийг засаглах хөдөлгөөнт хүч болсон. Энэ нь ялангуяа үндэстний улс төр, эдийн засгийн түүх, үндэстэн байх, үндэсний соёлын төлөөлөл, түүх бичлэгийг эргэн харж, дахин тунгаасан шилжилт болж байна. Эл агуулгад музей нь хана хэрэмгүй хаана ч байж болох ба экомузейн үзэл санааг давхар шингээсэн байв. Гуравдугаарт, 1960-аад оноос Англи-Саксон хэлт орнуудад музейн үүргийг радикал дахин шинжилж, ингэхдээ музейн уламжлалт сан хөмрөг, баримт бичигт суурилсан судалгаанаас завсарлаж, нийгэм соёлын, нийгмийн судалгаанд анхаарсан явдал байв. Үүний гал цахисан тод жишээг Петр Вергогийн редакторласан “*The New Museology*” (1989) бүтээл нотолсон юм (Смедс, 2021, 70-71) гэжээ. Керстен Смедс, Петр Дэвис нарын

дэвшүүлсэн санаа ерөнхийдөө төстэй, харин Шведийн музей судлаач Англи-Саксоны жишээг англи хэлээр хэвлүүлсэн бүтээлээр баяжуулж, тодотгосон байна. Эдгээр онолын санаануудыг өдгөө бид цуглуулга төвтэй музей, хүн төвтэй музей зэргээр таних төдий байгаа билээ.

Шинэ музей судлалын хөгжилд онцгой байр суурьтай “The New Museology” бүтээлд Петр Верго (1989) “хуучин музей судлал” музейн арга зүйн судалгааг хэтэрхий их, харин музейн зорилго, зорилгыг байхгүйтэй адил бага, бүхэлдээ хангалтгүй судалгаатай байна гэж шүүмжилж, хөгжлийн дараагийн шат хэрэгтэй болжээ гэж тодорхойлсон юм. Хэлний асуудал чухал байсан 20-р зууны музей судлалд англи хэлээр хэвлүүлсэн тус бүтээл орчуулсан эсэхээс үл хамаарч, музейн сургалтын хөтөлбөрийн зайлшгүй уншиж судлах сурах бичиг болсон байдаг. Харин Керстен Смедс глобал эл хэлний хүртээгдэх ойлголтыг газар зүйн бүс, улс орноор хязгаарласан нь анзаарагдаж байна.

1983 онд ICOM-ын Ерөнхий чуулган шинэ музей судлалын талаар Лондонд, 1984 онд Эко музей-шинэ музей судлалын дадлага сургалт Квебекд зохион байгуулсан дариу ICOFOM-ийн шинэ музей судлалд дуу хоолой, тус нэмэр болж, 1985 онд Шинэ музей судлалын олон улсын хөдөлгөөн (*The International Movement for a New Museology, MINOM*)-ийг Португалын Лиссабон хотод үүсгэн байгуулсан байдаг. Хөдөлгөөний суурь үзэл баримтлал Квебекийн тунхаг: Шинэ музей судлалын үндсэн зарчим (*Declaration of Quebec: Basic principles for a new museology*)-д шингэсэн (*Хавсралт 1* үз) байдаг. П.Майранд “Шинэ музей судлалыг тунхаглав” (*The New Museology Proclaimed*) (1985) өгүүлэлдээ “Шинэ музей судлал нь шинэчлэлийг дэмжих санаачилга төдий зүйл биш. Музей судлалын зорилго, музей судлаачийн сэтгэлгээ, хандлагыг эрс өөрчлөхөд хувь нэмэр, хүчээ өгсөн” гэж дүгнэсэн юм. Эндээс хуучин музей судлалын хөгжилд сэтгэл ханамжгүй судлаачид хувьслын дараагийн шат, дараах түвшнийг музей судлалын онол, үзэл санааны илүү өргөн хүрээнд гаргаж тавьсан их судалгааны үр дүн харагдаж байна.

П.ван Мэншийн музей судлалын хувьсгал¹ үечлэлийг хожим Петр Дэвис эргэлзэлгүй хүлээн зөвшөөрч, шинэ музей судлалын онол, зарчмыг тодорхойлох, үүний үр дүнд буй болсон экомузей болон экомузей судлалын судалгааг тууштай хийж байгаа билээ. Тэрээр “Шинэ музей судлалын зарчмуудыг хүлээн зөвшөөрөхдөө музейн үндэс суурийг тавьсан үзэл санаа, өмнөх академик судалгааны шинэ чанараа үгүйсгэж болохгүй. Хуучин музей судлалын нэгэн адил шинэ музей судлал нь сайн эрдэм шинжилгээ, судалгаатай байж амжилтад хүрнэ. Гэхдээ судалгаа, шинжилгээний өөр арга барил, төрөл гарч болохыг үгүйсгэх аргагүй. Жишээлбэл, эрдэм шинжилгээний ажилтнууд уламжлалт эдийн соёлын судалгаанаас илүүтэй нийгмийн нөхцөл байдал эсвэл нийгмийн харилцааны тухай артефактаар судалж болно. Мөн бид шинэ музей судлалыг өвийн хүрээнд илүү өргөн хөгжүүлэх, ингэхдээ соёлын олон янз байдал, соёлын үнэт зүйл, соёлын биет бус өвийг шинэ музей судлалын нэг хэсэг, түүний партнер хэмээн ангилж, харгалзаж, анхаарах хэрэгтэй” (Дэвис, 2011, 62) хэмээн өөрийн судалгааны суурийг тавьсан юм. Шинэ музей судлалын олон улсын хөдөлгөөн (*MINOM*) суурь үзэл баримтлалаа “өв

¹ Энэ тухай тус сэтгүүлийн өмнөх дугаарт өгүүлсэн.

соёл, музейг шударга бус явдалтай тэмцэх, олон нийтийн хөгжлийг дэмжих, яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд ашиглах стратегиас суралцаж, харилцан нэгэндээ тусална. Бидний хувьд энэ нь эв нэгдэл, нийгмийн төслийн нэг хэсэг болохоос зүгээр нэг лоозон уриа биш. MINOM бол байгууллага ч, объектын тухай ч биш, харин хүмүүсийн тухай юм” (MINOM-ICOM, 2023) гэж цахим хуудсандаа тодорхойлжээ.

1980-аад онд өрнөдөд хүч түрэн хөгжсөн шинэ музей судлалд хүрээлэн буй орчин, байгаль экологи, нийгмийн ардчилал гэсэн хоёр чиглэл тодорхой анзаарагдах бөгөөд энэ нь нийгмийн музей судлал, экомүзейн үндэс суурь болж байна. Нарийвчилбал, үндэстний соёл, иргэншлийн төлөөлөл, эдийн засгийн, улс төрийн түүх, түүх бичлэг, эх сурвалжийг шүүмжлэх нь мэтгэлцээний нэг хандлага, соёлын өв, хаана ч музей байж болох (хана хэрэмгүй, ил задгай) эко музейн үзэл санаа бүхий бас нэг хандлага давамгайлж байгаа билээ.

Шинэ музей судлалыг олон нийтийн тогтвортой хөгжлийг чухалчилж байх үе буюу анхны үзэл санаа, арга барилыг Дэвис (2011) дараах бүтцээр үзүүлсэн. Үүнийгээ Дэвис өрнөдийн орчин үеэс пост модерн үе (1980-аад он) гэж үечилж, музейн стандартажсан уламжлалт ойлголтууд шинэ агуулгад хувиран, ажлын дадлага туршлага болон нутагшиж буйг харуулсан. Үүнийг музейн менежмент, байгууллагын чадавх, хүний нөөц, чанар, төлөөлөл, үйл ажиллагаагаар тодруулсан бөгөөд музей судлалын хувьсал өөрчлөлт, музейн тогтвортой хөгжлийн үнэлгээ, шалгуур үзүүлэлт болгох боломжтой юм.

Хүснэгт 1.1

Орчин үе	Пост модерн (1980-д он хүртэл)	Шинэ музей судлал
Эрэгтэй давамгайлал	Эмэгтэй давуу байдал	Үзэсгэлэнд эмэгтэйчүүдийн сайн төлөөлөл, олонх байх; музейн ажлын байранд эмэгтэйчүүд олонх байх
Мэргэжил	Олон талт	Олон талт үзүүлэлт; хосолмол ур чадвартай эрдэм шинжилгээний ажилтан
Тоо хэмжээ	Чанар	Гүйцэтгэлийн хэмжүүр; музей судлалын стандарт
Маягт (юу?)	Чиг үүрэг (Яагаад?)	Асуултыг дэмжих үзэсгэлэнгийн сэдэв; судалгааны янз бүрийн чиг баримжаа, хандлага
Захиран тушаах шатлал	Интерактив сүлжээнүүд	Сүлжээ (дотоод болон гадаад бүлэг ба институтийн зорилт)
Хувь хүмүүс	Нийгэмлэг	Олон нийтийн оролцоо; музейнүүд багаар ажиллах
Хаалттай системүүд	Нээлттэй системүүд	Сүлжээ (дотоод болон гадаад)
Материаллаг хувийн сонирхол	Соён гэгээрлийн (оюунлаг) сонирхол	Насан туршийн боловсрол; сайжруулсан сургалт; өгөөмөр сэтгэл
Мөлжих Exploitation	Хамгаалалт	Хадгалалт хамгаалах ёс зүй; дахивар, дахин боловсруулах, эрчим хүч хэмнэх
Хувь хүний эрх	Хувь хүний болон хамтын үүрэг хариуцлага	Эрхэм зорилгын тодорхойлолт; музейн мэргэжилтнүүд, байгууллагуудад зориулсан ёс зүйн удирдамж

Эсрэгцэх	Хамтын ажиллагаа	Соёлын бусад байгууллагатай харилцах
Гадуурхал	Хүртээмж	Хандалтын бодлого, хүртээмж, нийгмийн үүрэг
Сэргээн засварлах	Урьдчилан сэргийлэх	Хадгалалт хамгаалалтын тактикийг өөрчилсөн
Богино хугацааны	Урт хугацааны	Урт хугацааны зорилго тавих; эрхэм зорилго, тодорхой зорилгууд
Тусгаар тогтнол	Харилцан хамаарал	Музей хоорондын сүлжээ
Өсөлт	Тогтвортой байдал	Хадгалалт хамгаалалтын ёс зүйг баримтлах; хязгаарлагдмал нөөцийн хүрээнд ажиллах; орлого бий болгох хандлага
Өрсөлдөөн	Харилцан оршин тогтнох	Сүлжээ; байгууллагуудын хамтын ажиллагаа
Үйлдвэрлэлийн хэмжээ	Оролт болон гаралтын чанар	Үзэсгэлэн, цуглуулгын бодлого бүхий эрдэм шинжилгээ стандартыг сайжруулсан
Уламжлалт	Футурист	Шинэ хандлага; нийгмийн, байгаль орчны талаарх зорилго; шинэ технологи
Төвлөрөл	Төвлөрлийг сааруулах	Цахим музейнүүд
Соёлын давамгайлал	Соёлын ялгаа	Бусдын соёлыг тэмдэглэх; бусдын соёлыг хамруулах
Материаллаг хязгааргүй өсөлт	Өсөлтийг хязгаарлах	Хадгалалт хамгаалалтын ёс зүй
Төлөөлөл	Бодит байдал	Үзэсгэлэнгийн үнэн, ёс зүйтэй байдал

Шинэ музей судлалын талаарх дийлэнх бүтээлийг англи хэлээр хэвлэсэн (Дэвис, 2008) байдаг тул манай улсад өнөөг хүртэл шинэ музей судлалын онол, түүх тодорхой бус, бидний унаган хэл дээрх эх хэрэглэгдэхүүн, сурах бичгийн уламжлал, англи хэлний чадавх, үл тоомсорлох хандлагаас хамаарч байна. Үүний доторх экомүзейн судалгааг өдгөө П.Дэвис тэргүүлж байгаа бөгөөд түүний бүтээлүүд экомүзейг сонирхон судлах, биежүүлэн хөгжүүлэх манай улсын хэнд ч болов гарцаагүй тус нэмэр, чиг болох билээ. П.Дэвис (2010) Шинэ музей судлал, олон нийт, экомүзей хичээлийн лекцэд ICOM-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга асан Хьюг де Варин шинэ музей судлалын хандлагыг ялгахын тулд экомүзей гэсэн нэр томъёог анх санал болгосон. Шинэ музей судлал, экомүзей судлал хоёр бол орон нутгийн иргэдийг оролцуулсан музейг сурталчилж, тогтвортой хөгжлийг дэмжихийн тулд өвийн нөөцийг ашигладаг. 1971 онд Францын Дижон хотод ICOM-ын хурал дээр экомүзей гэдэг үгийг англи хэлээр *Ecomuseum* “экомүзей” гэж нэрлэжээ. Экомүзейн үзэл баримтлал нь 1970-аад оны эхээр байгаль орчны асуудал нийгэмд чухал болох үед гарч ирсэн. Экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, хэлэлцэхэд хамгийн их анхаарал хандуулж байсан тэр үеийн нийгэм, улс төрийн шууд тусгал нь экомүзей гэсэн нэр томъёо. Тэр цагаас хойш шинэ музей судлал, экомүзей судлал гэсэн нэр томъёог байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд чиглэсэн олон нийтийн өвийн төслүүдэд хэрэглэж байна. Орон нутгийн хөгжилд музейн гүйцэтгэх үүргийг сурталчилсан өөр нэг чухал хүн бол Францын музей судлаач Жорж Анри Ривьер юм. Тэрээр Варинтай хамт Францын

хөдөө нутгуудад орон нутгийн иргэдтэй хамтран туршилтын төсөл хэрэгжүүлсэн. Төслийн гол үзэл баримтлал нь нутгийн иргэд өв соёлоор хэрхэн орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх, орон нутгийн онцлогт тааруулан амьдралаа сайжруулж буйг тодруулахад чиглэж байв. Тэр үед де Варин, Ривьер нар өөр өөр үзэл бодолтой байсан. Жорж Анри Ривьер бол Францын хөдөөгийн нийгэмд алга болж буй соёлын өвийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг угсаатны зүйч байв. Үүний эсрэгээр, де Варин бол музейг ардчилалтай болгоход илүү анхаарч байсан. Хамтад нь авч үзвэл, эко музей судлалын онолын хэтийн төлөв нь газар нутаг, ландшафт, өвөрмөц байдал, хөгжил, ардчиллыг илүү чухалчилж музейн үүрэг, хариуцлагыг өргөжүүлж байсныг өдгөө бид харж болно. Энэ нь боломж бололцоо муутай ч алсын хараатай судлаачдын олон жилийн туршлага, улс орны эрх баригчдын үл ойлголцол, тэр байтугай тэдний дайсагналтай тэмцэж, шинийг санаачилж ажилласны үр дүн юм. Тэр үед би ICOM-ийн хурал чуулганд зөвхөн ажиглагч байсан. Өнөөгийн миний ажил мэргэжил болох шинэ музей судлал нь орон нутгийн хөгжил, олон нийттэй үүгээр эх сурвалжлан холбогдоно гэж өгүүлснийг оюутан байхдаа тэмдэглэж авсан байна. Эндээс уламжлалт болон шинэ музей судлалын онолын хүрээ, зарчим, ялгаа тодхон харагдаж байгаа.

Нийгмийн музей судлал *Sociomuseology* нь музейг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх үүрэг хүлээж, музей, нийгэм, хүний амьдралын уялдаа, харилцааг тодорхой болгож байдаг. Хүний тухай, хөгжил дэвшил, үйлчилгээ, хот хөдөөгийн төлөвлөлт зэрэг шинжлэх ухаан, мэдлэгийн талбаруудыг төгс нэгтгэн музей судлалтай холбож өгдөг юм. Хүн төрөлхтний биет, биет бус соёлын, байгалийн өвд нийгмийн тэгш байдал, нийгэм, эдийн засгийн оролцоонд суурилсан тогтвортой хөгжлийн нөөц бололцоог музей судлал болгох арга зарчимтай (Mbrigio C. Moutinho, 2007, 39). ИКОМ-д Нийгмийн музей судлалын олон улсын хороо (*International committee for Social Museology, SOMUS*) 2023 онд байгуулагдлаа.

Шинэ музей судлалын олон улсын хөдөлгөөн (*MINOM*) нь нийгмийн музей судлалын (*Social museology*) үзэл санааг ялангуяа өмнөд америк, Испани, Португал орнуудад түлхүү хөгжүүлж байна. 2013 оны 8-р сарын 7-оос 10-нд *MINOM*-ын ээлжит чуулган Бразилын Рио-де-Жанейрод чуулсны дараа 8-р сарын 10-17-нд ICOM-ийн 23-р Ерөнхий Чуулган “Музей (ой санамж+бүтээлч)=нийгмийн өөрчлөлт *Museums (memory+creativity)=social change*” сэдэвтэй үргэлжлүүлээд чуулсан байдаг. *MINOM* (2013)-ын тунхаг нийгмийн музей судлалыг, ялангуяа өмнөд америк, Испани, Португал зэрэг улсын музейг нийгмийн хариуцлагатай уялдуулан хүчирхэг зэвсэг болгосон (Chagas, Assuncro dos Santos & Glas, 2014, 99-100). Харин Ерөнхий чуулганаас музейгээр нийгмийн өөрчлөлтийг сурталчилж ажиллахыг дэмжсэн байдаг. Музей нь тэр чигтээ бүтээлч ур чадварын сан хөмрөг, түүнд агуулсан ой санамжийн нэгдэл юм. Үүний хөдөлгөгч хүч нь оролцогч хүмүүс, ялангуяа музейн мэргэжилтнүүд, олон нийт болдог юм. Музейн орчинд бүтээлч сэтгэлгээгээр идэвхэжсэн ой санамж нь манай нийгэмд өөрчлөлтийг бий болгоно (Carlo Roberto Ferreira Brandao, 2014, 89) гэжээ. Ингэж нэг хотод дараалан чуулсан хоёр чуулган нийгмийн музей судлалд төвлөрч, микро болон макро түвшинд музейгээр нийгмийг өөрчлөх, музейг соёл хоорондын гүүр болгох талаар хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлсэн байдаг.

Нийгмийн хариуцлага, музей хоёрыг нэгтгэсэн үзэл санаатай MINOM-ын тунхаг (*Declaration MINOM Rio 2013*)-г “Музей судлалын зорилго нь ой санамжтай холбоотой ухамсраар дамжуулан нийгэм, улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг хүчлэх. Ингэхдээ нийгмийн хурц асуудал, төрөл бүрийн хүчирхийллийг туулсан, дурсан санагалзах төлөөлөгчдийг хамгаална” гэсэн байдаг. Эндээс нийгмийн үүрэг, хариуцлага хүлээсэн тов тодорхой үзэл санаа, баримтлалтай нийгмийн музей судлал испани хэлт улс орнуудад хүчтэй хөгжиж буйг тунгааж болно.

Манай улсын музей дэх түүхэн хүүрнэл, өгүүлэмж нийгмийн өөрчлөлтөөр хэрхэн өөрчлөгдөж, ямар үр дүнд хүрсэн талаар музей судлаач Салли Ватерсон судалж, онолжуулсан. Тэр бээр музейнүүд үндэсний түүх, соёлоо сэргээн, үндэсний өөриймсөл/ижилсийг бүтээж, хэрхэн өгүүлж буйг “Жинхэнэ Монгол: Монголын музейнүүд, Үндэсний өөриймсөл/ижилсийг бүтээх нь” (*Jinhin Mongol/ True Mongolian – Museums of Mongolia negotiating the twentieth century*) (2014) судалгааны бүтээлдээ тодруулсан. Түүний бүтээлд XX зууны сүүлч, 21-р зууны эхэн үед монголын музейд томоохон өөрчлөлт гарсан, музейн мета өгүүлэмжийг өөрчлөхөд хүчтэй нөлөөлсөн шалтгаан нь улс төр, олон улсын харилцаа, Монголын эдийн засгийн уналт, Их Монгол Улс байгуулагдсаны ой, Чингис хааны мэндэлсэн өдрийг тойрсон соёлын үйл ажиллагаа, үндсэрхэг үзэл санаа юм гэж нийгмийн музей судлалын үүднээс тайлбарласан байдаг. Тэр үеэс монголын музей нь Чингис хааныг монголын түүхийн гол дүр, улс орны оршин байх утга учир, эрт эдүгээ үеийн уламжлалт соёлын холбоо хамаарал хэмээж, дотоод, гадаад улс төрийн, ард түмний нөлөө, сонирхлын үр дүнд үндэсний шинэ өвөрмөц байдлыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулж, шинэчлэн найруулсан өгүүлэмжтэй болж буйг тодорхойлсон. 1990 оноос хойших гадаад дотоодод аялсан Чингис хааны сэдэвтэй олон үзэсгэлэн, 2020 онд байгуулсан Чингис хаан үндэсний музей бол эл шинэчилсэн найруулга, өгүүлэмжийн биежсэн үр дүн, нотолгоо юм.

Олон улсын хүний эрхийн түгээмэл тунхаг (1948), Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц (1972) гээд хүн төрөлхтөнд нийгмийн музей судлал нь нэгдүгээрт, музейг байгаль, нийгмийн эерэг сөрөг олон янз, уур амьсгалын өөрчлөлт, арьс өнгө, хүйс, ялгаварлан гадуурхал колоничлол, ядуурал, дайн байлдаан зэрэг олон сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг, мэтгэлцээний талбар болж, хөгжлийн шийдэл гарц болдог. Улс орны музейнүүд эл дурдсан асуудлыг нийгмийн хариуцлагын үүднээс авч үзэхээс өөр аргагүй юм. Учир нь музей нийгмийн бүхий л цаг үеийн түүх, өнөө үеийн гэрч эдийн соёл, баримт мэдээллийг баримтжуулан шүүн хэлэлцэх сургаалт нотолгоо болж байдаг. Нийгмийн музей судлал нь манай улсын хувьд олон нийтийг хүүхдийн хүчирхийлэл, авлига, хүний наймаа, хүйсийн тэгш байдал, ялгаварлан гадуурхал, орчин үеийн боолын, бэлгийн мөлжлөг зэрэг нийгмийн эмзэг асуудлаар музейд тайлан таниулах, харилцаа судалгаа тодруулах замаар нийгмийн дэвшилтэт өөрчлөлтөд хувь нэмэртэй. Нийгмийн музей судлалын сайн үр дүн, туршлага олон улсын музейнүүдэд нутагшсан байх нь түгээмэл. Жишээлбэл, Глазгов хотын нэгэн музей хотынхоо оршин суугч, эцэг эх, хамаатан садны хүүхдүүд багачуулаа зодож занчсан, амь насыг хохироосон түүх намтартай ахуйн эд зүйлийг цуглуулж, чамбай судалгаатай тайлал, төлөөлөл бүхий ажлаар хүчирхийллийн тоог багасгаж, таслан зогсоосон байдаг. Нийгэм, гэр бүлийн соёлын

нөлөөлөл, солбицол дахь хүүхдийн эрх зүй, түүх, эдийн соёлын судалгааг музейн эрдэм шинжилгээний ажилтан судалж, үзэсгэлэнгийн дизайнер, боловсролын зэрэг олон ажилтны хамтын хүчээр биежүүлэн үзэгчид, эрх мэдэлтэн, шийдвэр гаргагчдад нөлөөлдөг байна. Ийм хотын иргэд “манай хотын нэгдүгээрт хүүхэд байдаг” хэмээн яриа өрнүүлэх нь элбэг. Үүнтэй адил соёлын олон янз байдал, соёлын зөрүүтэй харилцаа, шашны асуудал, хүний эрх, хүйс, жендер, олон янз байдал, нийгмийн социал медианы болон иргэний дайн, соёлын өвийн хууль бус худалдаа, дээрэм тонуул, диколончлол (*museum decolonization*) гээд маш өргөн хүрээнд нийгмийн тулгамдсан асуудлыг музейд шийдвэрлэж, нийгмийн үүрэг хариуцлагаа ухамсарлан хошуучилж байгаа тухай олон жишээ байдаг. Хоёрдугаарт, үндэстэн, хил хязгаар доторх улс төр, нам, эвсэл, улс төржилт, дарангуйлсан бүлгэмийн дуу хоолой зэрэг явцуу захиалгат хэрэгцээнд үйлчилж, туйлширсан гажуудал болж болохыг анхаарууштай. Олон улсын хэмжээнд нийгмийн чиг баримжаа, хандлагын тухай агуулга хэтийдэж шингэсэн музейн тодорхойлолтыг 2019 онд Киотод болсон МОУЗ-ийн 34-р Ерөнхий чуулганаар хэлэлцэж, цуцалсан байдаг. Тус тодорхойлолтын тэргүүн агуулгыг “музейнүүдийг ардчилах”, “өнгөрсөн өнөөгийн тухай шүүмжит харилцаа өрнүүлэх”, “сөргөлдөөн”, “нийгмийн итгэлцэл”, мөн англи хэлний илэрхий “жаргон” үгс, агуулгаар найруулсан нь 2007 онд баталсан музейн өмнөх тодорхойлолтоос эрс өөрөөр шинэчилсэн, залгамж чанаргүй алдаатай болсон юм. Үүнд: *“Museums are democratising, inclusive and polyphonic spaces for critical dialogue about the pasts and the futures. Acknowledging and addressing the conflicts and challenges of the present, they hold artefacts and specimens in trust for society, safeguard diverse memories for future generations and guarantee equal rights and equal access to heritage for all people. Museums are not for profit. They are participatory and transparent, and work in active partnership with and for diverse communities to collect, preserve, research, interpret, exhibit, and enhance understandings of the world, aiming to contribute to human dignity and social justice, global equality and planetary wellbeing”*. ICOM Нидерландын удирдах зөвлөл музейн эл тодорхойлолтын үймээн самуунтай хэлэлцүүлгийг “гишүүд нийгмийн чиг баримжаа ихтэй шинэ хандлагыг эмзэг асуудал хөндсөн улс төржилт гэж үзэж байв. Европын уламжлалт “цагаан”-ны ноёрхол, музейн цуглуулгад чиглэсэн консерватив сөрөг шахалт, авторитар засаглалтай орнуудын цензур, либерал улс орнуудын дэвшилт хөдөлгөөн, татаасаа алдахаас эмээх, процедурын маневр хийх, харилцааны доголдол, англи хэлний давамгайлал, ялангуяа зөвлөлдөх хугацаа богино [зэргээр дурдан шүүмжилж С.Э] ICOM Франц болон Европын бусад хэд хэдэн улс тус тодорхойлолтыг үл зөвшөөрөн хойшлуулахыг хичээсэн” (The board of ICOM Netherlands, 2021) гэж илтгэжээ. Тэгэхээр нийгмийн музей судлалын дурдсан нөхцөл байдлыг ханган, тэнцвэртэй хөгжүүлэх нь музей нийгмийн харилцаа, нийгмийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох, эдийн засгийн үр дүн, хүний эрх, хөгжилд ахиц дэвшил гээд өргөн хүрээнд тус нэмэртэй юм.

Экомузей. 20-р зууны 2-р хагаст экологи ба музей гэсэн үгийн олон янзын хослолуудаас шилэгдэн сонгосон экомузей нь музей судлалын судалгааны шинэ чиглэл, ойлголт болж хөгжсөн юм. 1971 онд Дижон хотод, Францийн музей судлаач Хьюг де Варин анх экомузей (*Icomusie*)-г олон улсын музейн хуралд

дурдсан цагаас судлаачдын дунд ярьж ойлголцох эл ухагдахуун ойлголт үүсжээ. Тухайн үеийн францын нийгмийн анхаарлын төвд хүрээлэн буй орчны асуудал, ногоон хөдөлгөөн орж, улс төрчдийн халуун сэдэв болж байжээ. Эгзэгтэй энэ үед Хьюг де Варин нарын музей, байгаль орчны нэгтгэлийн тухай ойлголт, үзэл санаагаа эл *Йcomisue* үгээр түлхүүрдэн илэрхийлсэн байдаг. Улс төрчид экомүзей нэр томъёогоор хүрээлэн буй орчинтой музейг нийлэгжүүлбэл инээдэм тохуу болох вий хэмээсэн болгоомжлол, нөгөө талаар шинэ содон, шинэлэг мэдлэг болохыг ойлгомогц олзуурхан эзэрхгэх, өөрийн мэдлэг болгохоор булаалдах зэргээр анхааралд өртөж байв. Жишээлбэл, францын хүрээлэн буй орчны сайд ээлжит эвентийн сэдэв сонгох үед, зарим хүмүүс экологийн музей, ногоон музей, францын бүс нутгийн парк музей, эко музей гээд янз бүрээр яриад байдаг. Харин би экомүзейг сонголоо гэжээ.

Тэр үед экомүзей гэж юу болох, юу биш болох гээд алдаа оноотой мэтгэлцээн маргаан музей судлаачдыг тойроогүй юм. Экомүзейг “New Larousse French Dictionary” тайлбар тольд “байгалийн сэргээн засварлах газар” буюу “*Natural conservation area*” хэмээн буруу тодорхойлсноос нэр томъёог англи хэл рүү хөрвүүлэх боломжгүй болгосон байна. Үүнийг Хэннэт Хадсон *eco* гэдэг үг *echo* буюу цуурай гэсэн үг болж, британи, англи хэлтнүүдэд ярвигтай асуудал дагуулаад байна, “тусгал”, “давтсан” гэсэн утгатай, музейний цуурайг илэрхийлж, жинхэнэ биш, музейн сүүдэр гэсэн ойлголт (Kennet, 1996, 18) юм хэмээн ёгтолж, тайлбарыг няцаасан байдаг. Унаган англи хэлт Петр Дэвис (2011) миний хувьд эко угтвар нь экологи байгальтай холбоотой юм, цуурай биш л дээ хэмээн Хадсоны хурц няцаалтыг зөөлрүүлсэн байдаг. Тэр цаг үеэ бодвол өнөөгийн музей судлалын ертөнцөд Петр Дэвис тэргүүтэй дагнасан судлаачид төрөн гарч, экомүзейн тодорхойлолт, загвар, шалгуур үзүүлэлт, шинж чанар бишгүй олон, судалгааны эх сурвалжууд арвижиж, тод гаргацтай болж байгаа билээ. Музей судлал дахь байгаль экологи, экомүзей судлалын хөгжлийн үр дүнд ИКОМ-д Музей ба Тогтвортой хөгжлийн олон улсын хороо (*International committee on Museums and Sustainable Development, SUSTAIN*)-г 2023 онд байгууллаа.

Ж.А.Ривьер (1985)-ийн экомүзей-хувьслын тодорхойлолт (*the ecomuseum-an evolutive definition*)-ын, Меншийнхээр хоёрдугаар хувьсгалын биежсэн тод баталгаа нь эко музей юм. Ж.А.Ривьер нь экомүзейн томоохон гурван тодорхойлолтыг музейн ажлын туршлагатайгаа уялдуулж, хувьслын агуулгаар хараалж бичсэн. Үүний нэг талаас бид судлаачийн практикийг онолд, онолыг практикт нийцүүлсэн мэдлэг, ур чадвар, нөгөө талаас биднийг экомүзейн хувьсал хөгжлийг таних боломж бололцоог өргөжүүлэн тус нэмэр болж байна. Тодорхойлолтуудын тухай Петр Дэвис (2011), Ж.А.Ривьер ажилдаа туршлагажих тусам түүний үзэл баримтлалд хувьслын шинж чанар илэрч байсан. 1973 оны анхны тодорхойлолтод экологи, байгаль орчныг хэт их баримталсан, 1978 оны тодорхойлолтод нутгийн байгалийн цэцэрлэгт хүрээлэн доторх экомүзейн хувьслын шинж чанарыг онцолж, орон нутгийн иргэдийн гүйцэтгэх үүргийг тодруулсан. 1980 оны сүүлийн тодорхойлолт нь маш сайн хувилбар болсон тул музей судлаачид олонтоо эшилдэг юм гэж дүгнэсэн. Эл тодорхойлолтод Ж.А.Ривьер “Экомүзейг төрийн байгууллага, нутгийн иргэд хамтран зохион бүтээж, нээдэг. Төрийн эрх мэдлийн оролцоо нь мэргэжилтнүүд,

тоног төхөөрөмж, хөрөнгийн эх үүсвэр байна; Орон нутгийн хүн амын оролцоо нь тэдний хүсэл эрмэлзэл, мэдлэг, хувь хүний хандлага байна. Экомүзей нь нутгийн ард иргэд өөрсдийнхөө дүр төрхийг хардаг нэг төрлийн толь бөгөөд үүгээрээ тухайн харьяалагдах нутаг дэвсгэр болон эрт цагаас янагш популяц, цаг хугацааны хувьд залгамж чанартай, хязгаарлагдмал, эсвэл эс хязгаарлагдмал байдлаар тайлал эрэлхийлж байдаг. Ингэж нутгийн ард түмний үйлдвэрлэл, зан заншил, өвөрмөц онцлогоо хүндэтгэн, бусдад өөрсдийгөө ойлгуулах толь болдог. Хүн ба байгалийн хүйн холбоон илэрхийлэл, хүний амьдралын хэв маягийг байгалийн орчинд дүрслэн байрлуулдаг. Онгон зэрлэг байгалийг уламжлалт, үйлдвэрлэлийн нийгэмд дасан зохицож, сүлэлдсэн дүр төрхтэй дүрсэлдэг. Энд орон зайн тайлал - зогсоол эсвэл зугаалах зам болгон тусгайлан зассан газар байна. Хүний үүслийн өмнөх, балар эртний, дундад түүхэн цаг үеэс өнөө гээд бүхий л цаг хугацааны илэрхийлэмж, хүний хараа хүрэх газрын байцыг тайлбарлан таниулахдаа ирээдүйд өвлөн дамжуулах дүр төрхийг ямар нэгэн нэмэлт дүр эсгэхгүй, байгаа байдлаар санал болгоно. Тайллын үүрэг нь мэдээлэл өгөх, эргэцүүлэн бодуулах, шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийлгэх явдал. Экомүзей нь оршин суух хүн амын өнгөрсөн ба одоо, хүрээлэн буй орчныг судлах судалгааны байгууллагуудтай хамтрах, мэргэжилтэн бэлтгэхэд хувь нэмэртэй лаборатори. Нөгөө талаас хүн амын байгалийн болон соёлын өвийг хадгалах, хөгжүүлэхэд тусалдаг байгаль хамгаалах төв, бас нөгөө талаас ард иргэдийг орчныг хамгаалах ажилд татан оролцуулах, ирээдүйн тухай тодорхой ойлгуулж сургах, байгаль хамгаалах нийтлэг зарчимд суурилсан сургууль юм. Экомүзейд олон янз байдал хязгааргүй тул түүний элементүүд нь ихээхэн ялгаатай байдаг. Үүний загварын зураглал нь өөрөө хаалттай биш, хүлээн авдаг, буцааж өгдөг гурвалж байна” (Ж.А.Ривьер, 1985, 181-182) гэсэн. Эл тодорхойлолтын орчуулгын чанарыг үл анзаарсан ч “орон зайн тайлал” буюу *an interpretation of space* зэрэг бүдэг бадаг, бидний үл таних нэр томъёонууд мэдээж байгаа. Энэ нь зогсоц, зугаалах замд хүн мэдээлэл авч, эргэцүүлэн бодож, дүн шинжилгээ хийж, магадгүй шийдвэр гаргахад хүргэх тайлал, байцыг хэлж байна. Тэгвэл Петр Дэвис (2005, 2011) тус тодорхойлолт дахь “ард иргэд”-ийг хоорондын холбоо хамааралтай бүлэг; хамт олон “*community*” болохыг; хязгааргүй олон янз байдал “*limitless diversity*”-г экомүзейд нутгийн иргэд, музейн ажилтан гээд хүссэн хэн ч байхыг; “орон зайн тайлал”-ыг барилга байшин, музейн газраар үл хязгаарлан бүхий л зүйл оршин байх бүсийн газар нутаг болохыг; газар зүйн бүсээр авч үзэх чухал тулгуур ойлголтод тусгай утга учир агуулга нь музейтэй нэгдэж, “соёлын хүртэж мэдрэх чулуу”, “*cultural touchstones*” болохыг тайлбарлаж, олон нэр томъёонд нухацтай хандсан байдаг.

Ж.А.Ривьер франц болон олон улсад экомүзей байгуулах, бусдыг экомүзей байгуулж буй явдалд санал зөвлөгөө чиглэл өгсөн олон жилийн арвин туршлага нь эл тодорхойлолтыг төгөлдөржүүлсэн юм. Тэр бээр анхны экомүзейг Шведийн Стокхольм хотын Скансэн парк ил задгай музей²-ээс санааг авч, францын байгаль

² Ил задгай музей нь хувийн сууц, байшинг тодорхой цэцэрлэг, газрын байцад нүүлгэн шилжүүлж артефакт болгодог бол экомүзей цэцэрлэг, газрын байц, хүний амьдралын орчныг өмнөх, одоо байгаагаар нь буцаан сэргээж, тодруулдаг. Ямар нэг нүүдэл, шилжүүлэлт хийдэггүй.

хүний холбоо хамаарал, харилцааны үр дүнгээр хүнийг бүхий л талаар сургах зорилго, агуулгатай болгон практик дээр хөгжүүлж, биежүүлсэн байдаг. Энэ нь соёлын хөтөлбөр, архитектурын шийдэл төдий байсангүй (Franzois Hubert, 1985, 186). Сонирхуулахад, Скэнсэн ил задгай музейн үндсэн санаа нь янз бүрийн бүсийн хөдөө орон нутаг, цаг хугацааны төлөөлөл, хамт олон, бүлгийг нэг дор чулуулан агсаж, гар урлал, мал аж ахуй, урьд цагийн тоног хэрэгсэл, ёс заншлаар амьдралын орчныг угсаатны зүйн ажиглалт, нийтийн уламжлал дээр үндэслэж бүтээсэн байв. Үүнтэй төсөөтэй паркийн ил задгай музейнүүд Норвег, Швед, Финландад 1970-аад оны үеэс буй болсон байдаг.

Судлаачид экомүзейг уламжлалт музейтэй харьцуулан тодорхойлолт, загвар, шалгуур үзүүлэлтийн ялгааг тодруулж гаргасан. Хьюг де Варин (1996) Экомүзей судлалын тодорхойлолтыг уламжлалт музей болон экомүзейн ялгаагаар анх дэвшүүлсэн. Үүнд:

Музей	Экомүзей
Цуглуулга	Өв
Барилга	Газар нутаг
Үзэгчид	Бүлэг хамт олон

Рене Ривард (Дэвис, 2011, 82) уламжлалт музейг байшин дотроо цуглуулгатай, эксперттэй, тодорхой техниктэй, үзэгч, олон нийт байшингийн гаднаас дотогш ордог, экомүзейг газар нутаг, өв, ой санамж, хүн амтайгаа цугтаа байдаг хэмээн харьцуулж, экомүзейн төлөөллийг оршин суугчид, ландшафт, өв, хараа байц, ой санамжийн сан, архитектур, үзэгчид, ахмад, соёлын хөрөнгө, ёс заншил, уламжлалыг нэрлэсэн.

Уламжлалт музей нь байгаль орчин, бүлэг хамт олноос тусдаа оршдог бол экомүзей бол эдгээрийн нэгийг нөгөөгөөс салгах боломжгүй сархинаглан нөхцөлдөж, өөр хоорондоо харилцан хамааралтай болохыг П.Дэвис дараах зургаар үзүүлсэн.



Зураг 1. П.Дэвисийн уламжлалт музей, экомүзейн харьцуулсан загвар

Хүснэгт 1.2. Экомүзей судлалын тодорхойлолт, шалгуур үзүүлэлт

Бойлан (1992) эко-байгальд чиглэсэн музей, уламжлалт музейн хоорондын ялгааг тоочиж, шалгуурыг жагсаасан. Шалгуур тус бүрд 1-ээс 5 хүртэл оноо өгнө. 2-3-р багана музейн шинж чанарыг илэрхийлэх бөгөөд нийт оноо нь 20-оос дээш байвал тухайн байгууллагыг эко музей гэж үзнэ.

Шалгуур	Музей	Экомүзей
Хамрах хүрээ	барилга	газар
Тайлбарын хараа	цуглуулга	өвийг цогц утгаар
Байгууллагын тэргүүлэх	сахилга баг	салбар хооронд
Үзэгчдийн жишиг	үзэгчид	нийгэмлэг
Хяналт	музей, хамт олон	хамтлаг, байгууллага

Дэвис (1999)-ийн экомүзейн шалгуур үзүүлэлт

- Музейгээс том талбай
- Хэсэгчилсэн талбай ба ин ситью (*in situ*) тайлбар
- Үзмэр өмчлөхөөс ялгаатай хамтын ажиллагаа, түншлэл
- Музейн үйл ажиллагаанд орон нутаг, оршин суугчдыг татан оролцуулах
- Нэгдмэл болон хэсэгчилсэн тайлбар

Олон улсад музей судлалын онол, түүхийн залгамж Шинэ музей судлал нь нийгмийг өөрчлөгч динамик хүч, ялангуяа байгаль экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийг дэмжих, хүний хөгжил, орон нутгийн иргэдийн оролцоо, ядуурал бууруулах, Хүний эрхийн түгээмэл тунхаг (1948), ЮНЕСКО-гийн Соёлын амьдралд хүмүүсийн өргөн оролцоо, хувь нэмрийн талаарх зөвлөмж (1976)-тэй уялдсан зэрэг өргөн хүрээний хэрэгцээ шаардлагын улмаас хөгжсөн. Мөн музей судлаачдын уламжлалт музей судлалыг шинжлэх ухаан болгох гэсэн хэтийдсэн мэрийлт, музейг “хорго”-д байрлуулсан мэт амьдралаас тусгаарлан холдуулах, тодорхой техник, зааварчилгааны дагуу зөвхөн экспертүүд ажиллах хөшингө баригдмал загвар, нөхцөлөөс гаргах хөгжлийн дараагийн шат болгож шинэ музей судлалыг хөгжүүлсэн байна. Үүний төлөө шинэ музей судлалд байгаль-хүрээлэн буй орчин, хүний эрх, хөгжил, музейн нийгмийн үүрэг, хариуцлага, харилцаа нэн чухал болж, нөөц чадавхдаа тулгуурлан шинжилсэн үр дүнгээ улс орны засаглал, хэл, соёлын загварт тохируулан буулгаж байна.

Хэрэвзээ, Питер ван Меншийн музей судлалын хоёрдугаар хувьсгалын дотор шинэ музей судлал, Марксист-Ленинист музей судлал нь биесээсээ ангид тусдаа, зэрэгцээ хоёр хандлага байдаг гэснээр өнөөгийн бид өөрсдийгөө шүүн хэлэлцвэл манай улсын хувьд шинэ музей судлал болон үүний биежсэн баталгаатай болж хараахан нэвтэрч, хөгжөөгүй мэт. Гэвч Салли Ватерсоны Жинхэнэ Монгол: Монголын музейнүүд, Үндэсний ижилсэл/өөриймсөл бүтээх нь (*Jinhin Mongol/True Mongolian – Museums of Mongolia negotiating the twentieth century*) (2014) сэдэвтэй, англи хэлээр буулгасан докторын ажлаар нийгмийн музей судлал нэгэнтээ хөгжиж эхэлсэн нь тодорхой байна.

Бидний хүрээлэн буй байгаль орчин, эх газрын хуурай, эмзэг эко систем, уур амьсгалын өөрчлөлт, үүнтэй салшгүй уялдаж, мөн даган өөрчлөгдөж буй амьдралын хэв маяг, аж ахуй, бидний мэдлэг, ёс заншил уламжлал, тогтвортой хөгжлийн бодлого, засгийн газрын дэмжлэг, эдийн засгийн хөшүүргэ, хувийн

хэвшлийн болон айл өрхийн амьжиргаа залгах сонирхол, туршлагатай эксперт судлаачдын хамтаар экомүзей хөгжих найдвартай нөөц суурь болох нь дамжиггүй юм. Үүнээс манай улсын соёлын өв, музейг судалсан судлаачдын бүтээл, аймгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт газар, Дэлхийн өвд бүртгэсэн цогцолбор газар, Дархан цаазат газар, нутаг, хот суурин, хүн ард зэргийг тухайлан нэрлэж болно.

Ашигласан материалын жагсаалт

1. Chagas M., Assuncro dos Santos P & Glas T. 2014. *Sociomuseology in Movement: MINOM Rio Declaration. Museum International*. Paris: ICOM.
2. Davis, Peter. 2005. *Places, 'cultural touchstones' and the ecomuseums*. In Corsan, G. (ed.) *Heritage, Museums and Galleries: An Introductory Reader*. London and New York: Routledge.
3. Davis, Peter 2011, *Ecomuseums A Sense of Place*. Continuum International Publishing Group.
4. Davis, Peter. 1999. *Ecomuseums A Sense of Place*. In *Leicester Museum Studies series*. Leicester: University of Leicester.
5. Franzois, Hubert. 1985. "Ecomuseums in France: contractions and distortions." *Museum Images of the ecomuseum*, No148 (Vol XXXVII, n°4) by UNESCO.
6. Hudson, Kennet. 1996. "Ecomuseums became more realistic." *Nordisk Museologi*, 2: 11-19.
7. International movement for a new Museology. <http://www.minom-icom.net/about-us> retrieved 2023.
8. Maggi, Mauriza., Falletti, Vittorio. June 2000. *Ecomuseums in Europe: What They Are And What They Can Be*. Torino: IRES – Istituto di Ricerche Economico-Sociali del Piemonte.
9. Mбrio C, Moutinho. 2007. "Evolving definition of sociomuseology: Proposal for reflection." *Cadernos De Museologia*, №28. Edizxes Universitбrias Lusyfonas.
10. Mayrand, Pierre. 2014. "The New Museology Proclaimed." *Museum International*, Vol 66: 115-118.
11. Riviere, Georges Henri. 1985. "The Ecommuseum – an Evolutive Definition." *Museum: Images of the ecomuseum*, No148 (Vol XXXVII, n°4) by UNESCO.
12. Roberto, Carlo., Ferreiro, Brandao. 2014. "A Report on the 23rd ICOM General Conference in Rio de Janeiro, Brazil." *Museum International №253-256*, by ICOM and Blackwell Publishing.
13. Sally, Watterson. 2014. "Jinhin Mongol/True Mongolian – Museums of Mongolia negotiating the twentieth century." Doctor's dissertation., University of Deakin, Australia.

14. Smeds, Kertin. 2021. "Critical Museology, Social Museology, Practical Museology or what? -International Museologies and Scandinavia." *Museum Studies – Bridging Theory and Practice* Nina Robbins, Suzie Thomas, Minna Tuominen, Anna Wessman (Eds). by ICOFOM University of Jyvaskyla, Open Science Centre.
15. "Basic principles of the integral museum." *Revista Museum*, Vol.II, by the United Nations Educational, Scientific and Cultural Organization in Paris, and by digitalization IΘ Ediciyn Brasulia, 2012 publicacion-mesa-redonda-vol-ii-pt-es-en.pdf (ibermuseos.org)
16. The board of ICOM Netherlands. 2020. "The museum definition: a fact sheet." July 2020. International Council of Museums. 2023.06.01. https://icom.museum/wp-content/uploads/2021/01/10-07-29_fact-sheet-museum-definitie_ENG.pdf
17. UNESCO. 1960. "UNESCO Regional Seminar on the Education Role of Museums, №38." 7-30 September 1958. UNESCO Digital Library.
18. Vergo, Peter. (Ed.) 1989. *The New Museology*. London: Reaction Books.

ХАВСРАЛТ

Declaration of Quebec: Basic principles for a new museology

Universal considerations

In a modern world which is attempting to muster all the resources that can contribute to development, museology must seek to extend its traditional roles and functions of identification, conservation and education to initiatives which are more far-reaching than these objectives, and thus integrate its action more successfully into the human and physical environment.

In order to achieve this objective and at the same time involve the public in its activities, museology must have increasing recourse to interdisciplinarity, modern methods of communication used in all cultural action, and modern management methods which involve the consumer.

While preserving the material achievements of past civilizations and protecting the achievements characteristic of the aspirations and technology of today, the new museology—ecomuseology, community museology and all other forms of active museology—is primarily concerned with community development, reflecting the driving forces in social progress and associating them in its plans for the future.

This new movement puts itself firmly at the service of the creative imagination, constructive realism and the humanitarian principles upheld by the international community. It has become a way of bringing people together to learn about themselves and each other, to develop their critical faculties and express their concern to establish together a world which takes a responsible attitude towards its own intrinsic riches.

In this context, the concerns of the movement, which is anxious to adopt a global approach, are scientific, cultural, social and economic.

The movement utilizes all the resources at the disposal of museology (collection, conservation, scientific research, restitution and dissemination, creativity) and adapts them to each environment and project.

Declaration

Considering that more than fifteen years of experience of a new type of museology—ecomuseology, community museology and all other forms of active museology—throughout the

world has been a critical factor in the development of the communities which have adopted this method of managing their future,

Considering the need felt by all participants in the various meetings and by the speakers consulted to do more to achieve recognition for this movement,

Considering the will to establish the organizational basis for joint reflection and experiments conducted on several continents,

Considering the value of a reference framework designed to promote the operation of the new forms of museology, and of linking principles and means of action together in this way,

Considering that the theory of ecomuseums and community museums (neighbourhood museums, local museums) is based on experiments conducted in various areas over more than fifteen years,

The following is adopted:

1. that the international museum community be invited to recognize this movement and to adopt and accept all forms of active museology in its typology of museums;
2. that all possible steps be taken to ensure that the public authorities recognize local initiatives to apply these principles and assist in their development;
3. that, in this spirit, the following permanent structures be established, in close collaboration, to make it possible for these forms of museology to develop and succeed: (a) an international committee for ecomuseums/community museums within ICOM (International Council of Museums); (b) an international federation for the new museology which might be associated with ICOM and ICOMOS (International Council on Monuments and Sites) and whose temporary headquarters would be in Canada;
4. that a temporary working group be formed with the following initial mandate: establishment of the proposed structures, formulation of objectives, implementation of a triennial programme of meetings and international collaboration.

Quebec, 13 October 1984
[Translated from French]